



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/149/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: У.Энхчимэг

Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан..	Error! Bookmark not defined.
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	Error! Bookmark not defined.
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....	Error! Bookmark not defined.
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан..	Error! Bookmark not defined.





2.1. Оршил

“Дашбалбар сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Д.Байгалмаа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу *“Дашбалбар сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.*

“Дашбалбар сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 16-наас 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймгийн Төрийн аудитын газрын захиалгаар “Хаан консалтинг аудит” ХХК-ийн аудитор У.Энхчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

“Дашбалбар сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймгийн Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.



2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Дашбалбар сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Чанартай бага, дунд боловсрол олгоход оршино.

“Дашбалбар сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус *“Дашбалбар сумын ерөнхий боловсролын сургууль”*-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. /

“Дашбалбар сумын ерөнхий боловсролын сургууль” нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Ахplorer программ хангамж ашигладаг байна.

“Дашбалбар сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар *“Дашбалбар сумын ерөнхий боловсролын сургууль”*-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.



Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын үзүүлэлтийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,050,742.4 мянган төгрөгөөс тооцон 21,014.85 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 21,014.85 мянган төгрөгөөр тооцсон нь тус байгууллагын санхүүгийн гол үзүүлэлт нь зардал байсантай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Дашбалбар сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 307,172.20 мянган төгрөгөөр буюу хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	250.20	-	(250.20)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	137,730.26	140,578.43	2,848.17
Үндсэн хөрөнгө	3,167,593.12	3,650,878.02	483,284.90
Хуримтлагдсан элэгдэл	(258,384.84)	(437,095.52)	(178,710.67)
Нийт хөрөнгө	3,047,188.74	3,354,360.93	307,172.20
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,047,188.74	3,354,360.93	307,172.20
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,047,188.74	3,354,360.93	307,172.20

Авлага дансны үлдэгдэл буурсан нь ХХОАТ-ын илүү төлөлтийн тооцоо хийгдсэнээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь мал амьтдын өсөлтөөс шалтгаалжээ.



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Улсын төсвийн хөрөнгөөр сургуулийн барилгад их засвар хийгдсэнээс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 499,699.9 мянган төгрөг, худлдан авсан 910.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 17,324.9 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,354,360.93 мянган төгрөг болж 307,172.20 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгөөр сургуулийн барилгад их засвар хийж, хөрөнгө оруулалт хийснээс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 834,185.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 834,185.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 834,185.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 834,161.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 14,813.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 4,852.5 мянга, урсгал засварын зардалд 6,219.1 мянга, томилолт, зочны зардалд 928.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 2,813.6 мянга, нийт 14,813.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 13 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 89,849.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 33,789.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 56,059.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 33,789.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тендерийн үнийг мөрдөөгүй худалдан авалт хийсэн байгаа нь нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41.1.2 дахь "энэ хуулийн 40.4-т зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөхийг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.



Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

2. 2019 онд нийт 137,800,291.69 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авснаас 24,479,965.2 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ е-баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудыг, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

Аудитаар илэрсэн 56,059.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Худалдан авах ажиллагааг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

“Дашбалбар сумын ерөнхий боловсролын сургууль” нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 45 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэмжлэл авсан тул зөвлөмж өгөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Дашбалбар сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Дашбалбар сумын ерөнхий боловсролын сургууль” -ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын **агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс** урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бэлтгэн нийлүүлэгчидтэй гэрээ дүгнэсэн тэмдэглэл огт үйлдээгүй байна.

1.2. Эрсдэл:

Гэрээ хэрэгжээгүй байх эрсдэлтэй.

1.3. Өгсөн зөвлөмж:

Бэлтгэн нийлүүлэгч, харилцагч тус бүртэй байгуулсан гэрээг дүгнэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг биелүүлнэ.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материалыг "Материал" нэрээр хангамжийн материалын дансанд бүртгээсэн, орлогодож зарлагдсан.



2.2. Эрсдэл:

Бодитой хийгдээгүй байх эрсдэлтэй.

2.3. Өгсөн зөвлөмж:

Материалыг санхүүгийн программд нэрээр нь тодорхой бүртгэх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд 40,798,899 төгрөгийн тавилга эд хогшил, 12,779,356 төгрөгийн ном бүртгээсэн байна.

3.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй нь тайлант хугацааны элэгдлийн зардал дутуу тооцоологдох эрсдэлтэй.

3.3. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийг зөв бүртгэж, элэгдлийн зардлыг тайлант үеүдэд хуваарилж бүртгэх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.



Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан
